

Эрхэм-8 уламжлалт эмийн хий, шар, бадганд нөлөөлөх жишиг итгэлцүүрийг тооцон, сурвалж судлалын хүрээнд судалсан дүн

Г.Ууганцэцэг¹, Б.Дэжидмаа², Ч.Чимэдрагчаа², Д.Амарзаяа², Ч.Эрдэнэчимэг², Т.Алимаа³

¹АШУУИС, Дархан-Уул аймаг дахь салбар АУС, НЭМ-УАУ-ны тэнхим

²Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн

³АШУУИС, Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль

Цахим шуудан: uugantsetseg@mmums.edu.mn, Утас: 99398593

Түлхүүр үг:

Эрхэм-8
Уушгины халуун
Жишиг
итгэлцүүр
Уламжлалт
анагаах ухаан

Товч утга:

Үндэслэл: Эрхэм-8 уламжлалт талх эмийг гүргэм, жуган, гиван, башига, дэгд, цагаан зандан, хонлэн, бонаа зэргээр найруулж, цул эрхтний халуун ялангуяа уушги, элэгний халуун, цус, шар хямарсан халуун, хижгийн халуун зэрэг шинэ ба хуучирсан халуунд хэрэглэдэг. Бид судалгаандаа Эрхэм-8 эмийн хий, шар, бадганд нөлөөлөх жишиг итгэлцүүрийг тооцон, сурвалж судлалын хүрээнд түүхий эдүүдийн амт, чадал, эрдэм, хэрэглээг тодруулан судлав. **Зорилго:** Эрхэм-8 уламжлалт эмийн хий, шар, бадганд нөлөөлөх жишиг итгэлцүүрийг тооцон, эмийн бүтэц, найрлага, уушгины халуун өвчнийг анагаах үйлдлийг УАУ-ны сурвалж зохиолуудаас харьцуулан судлах. **Арга, аргачлал:** Эрхэм-8 уламжлалт эмийн жор, түүхий эдийн судалгааг эм, эмт бодисын хий, шар, бадганд нөлөөлөх амтны чадлын жишиг итгэлцүүрийг тооцох аргыг (Б. Дагвацэрэн, 1996) ашиглан явуулав. Эрхэм-8 уламжлалт эмийн бүтэц, найрлага, уушгины халуун өвчнийг анагаах үйлдлийг уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолуудаас тодруулах зорилгоор эх зохиол сурвалж судлалын арга, задлан шинжилж нэгтгэн дүгнэх арга, магадлан жагсаах аргазүйг ашиглан эмийн найрлагад орсон түүхий эд тус бүрийн амт, чадал, эрдмийг холбогдох эх сурвалжаас тодруулж, өвчний заалтыг харьцуулан судлав. **Үр дүн:** Эрхэм-8 уламжлалт эмийн найрлага дахь эмт бодисууд нь шарыг дарах сэрүүн чадалтай, халууныг арилгах үйлдэлтэй ба гурван гэмд харилцан адилгүй үйлчилж байгаа бөгөөд шарыг дарах жишиг итгэлцүүр 0.68 буюу шарын гэмийг илүү сайн дарж, хийг дарах жишиг итгэлцүүр 0.58 байсан ба бадганыг дарах жишиг итгэлцүүр 0.16 байгаа нь бадганы гэмд тодорхой хэмжээгээр нөлөөлөхөөр байна. Эрхэм-8 эм нь сэрүүний эрхэм гиван, цагаан зандан, шимийн эрхэм жуган, гүргэм, тангийн эрхэм дэгд, башига, өвсний эрхэм хонлэн, бонгараар голлосон 8 хөл эмт бодисыг хувь тэнцүүлэн талхдаж найруулах бөгөөд цул, савын халуун ялангуяа уушгины халуун, хижгийн халуун, шинэ, хуучин халуун бүхнийг хоцроолгүй арилгана гэж сурвалж зохиолуудад тэмдэглэн бичжээ. **Дүгнэлт:** 1. Эрхэм-8 эмийн шарыг дарах чадал хамгийн их буюу 0.68, хийг дарах чадал 0.58, бадганыг дарах чадал 0.16 байна. 2. Эрхэм-8 эмийн найрлагад орж байгаа түүхий эдүүд ихэнх нь гашуун, амтлаг, эхүүн амттай, халууныг арилгах чадалтай, ялангуяа цул эрхтний халуун буюу уушги, элэгний халуун, цус, шар хямарсан халуун, хижгийн халууныг арилгах зэрэг үйлдэлтэй бөгөөд Эрхэм-8 эм нь амт, чадлаар найрагдсан эм байна.

Үндэслэл: “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолын “Увдисын үндэс”-ийн 35 дугаар бүлэгт уушгины өвчнийг 8 зүйлээр ангилсан бөгөөд үүнээс уушгины

халууныг халуун бүрхэх, халуунаар хатгуулах гэж 2 зүйлээр ялгасан байдаг. Халуун нь уушгинд дэлгэрвэл амьсгал давчдах, ар өврөөр хатгуулах, ханиахад

хатгуулах нь улам ихсэх, уруул, хумс нь хөхрөх, сууж босож чадахгүй болох, улбар шар буюу харавтар хүрэн өнгөтэй өмхий цэр гарах ба эмчилгээнд Гиван-10, Зандан-10, Гавар-3,5,7,9, Хонгорзул-12, Агар-10, Зову-8 зэрэг эмийг хэрэглэнэ гэжээ.²

Уламжлалт анагаах ухаанд шарын бэлгэ чанарын долоон бүрэлдэхүүн арвидсаны улмаас цус шарын халуун ихэдсэн шинж давамгайлан илэрдэг, цочмог халдварт бус өвчнийг ерийн халуун хэмээн нэрлэдэг бол цус шарын халуун, нянтай хавсарч халдварлан тархдаг эмгэгийг хижиг халуун гэх нь бий гэж цөөнгүй сударт тэмлэглэсэн байна.^{4-5,12}

Нэрт оточ Жамбалчойжиданзанпэрэнлэйн зохиосон “Увдисын далай” номын 66 дугаар бүлэгт уушгины өвчнийг засах тухай бичсэн ба уушгины өвчнийг найман зүйлээр ялгаж, уушги дэлгэрсэн өвчинд нүд улайх, хэл, уруул, хацар борлож, дуу сулрах, амьсгал цухалдах, цэр нь улаан байдаг. Уушгины халуун өвчинд Зову-8 буюу Эрхэм-8 эмийг өгнө гэжээ. Эрхэм-8 эмийн найрлагад ордог түүхий эдүүд нь сэрүүн чанартай бөгөөд өвсөн гүргэмийн цэцэг (*Carthamus tinctorius* L Safflower), жуган (*Schizostachoum chinense* Rendle), гиван (*Bostaurus domesticus* Gmelin), улаан башга (*Odontitis rubra* Baung.Opiz) газрын дээд хэсэг, дэгдийн цэцэг (*Gentiana decumbens* L.flora) цагаан зандан (*Santalum album* L. wood) мод холтос, хонлэн (*Lagoti integrifolia* Schischk.herb) газрын дээд хэсэг, бонаа (*Aconitum Kusnezoffii* Reichenb.flora) газрын дээд хэсэг зэрэг найрлагуудаас бүрдсэн цул эрхтний халуун ялангуяа уушги, элэгний халуун, цус, шар хямарсан халуун, хижгийн халуун зэрэг шинэ ба хуучирсан халуунд хэрэглэх заалттай.⁴

Эрхэм-8 эмийг сурвалж зохиолуудад цул эрхтний халуун ялангуяа уушги, элэгний халуун, цус, шар хямарсан халуун, хижгийн халуун зэрэг халуун өвчин бүхэнд хэрэглэх ба өвчний үс дэх шинж тэмдгийг үндэслэн хачир эмүүдийг нэмэрлэж өгөх тухай дурджээ.

Иймд бид судалгаандаа уламжлалт анагаах ухаанд халуун өвчнийг анагаахад өргөн хэрэглэдэг Зову-8 буюу Эрхэм-8 эмийн амт, чадал, эрдэм, хэрэглээг уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолуудад тулгуурлан тодруулан судлав.

Зорилго: Эрхэм-8 уламжлалт эмийн хий, шар, бадганд нөлөөлөх жишиг итгэлцүүрийг тооцон, эмийн бүтэц, найрлага, уушгины халуун өвчнийг анагаах үйлдлийг УАУ-ны сурвалж зохиолуудаас харьцуулан судлах

Арга, аргачлал: Судалгааны ажлыг түүх, эх сурвалж зохиолуудад тулгуурлан чанарын судалгааны аргаар явуулав. Судалгааны ажлыг АШУҮИС-ийн МАУОУС, МУАУХ, УАУТХ-ийн Эрдэм шинжилгээний төвийг түшиглэн 2024 онд хийж гүйцэтгэв.

Бие махбод гадаад орчинтойгоо шүтэн барилдах ёсны түгээмэл зүй тогтол ба эм найруулах зарчимд үндэслэн УАУ-д хэрэглэж ирсэн эм, эмт бодисын гэмд буюу биеийн ерөнхий төлөвт (өвчинд) нөлөөлөх амтны чадлыг Б.Дагвацэрэн нарын (1996) жишиг

итгэлцүүрийг (ЖИ) тооцох аргыг ашигласан. УАУ-д хэрэглэж ирсэн эм, эмт бодисын гэмд буюу биеийн ерөнхий төлөвт (өвчинд) нөлөөлөх амтны чадлыг жишиг итгэлцүүрийг (ЖИ) тооцох аргыг боловсруулсан бөгөөд $\Xi=f(\Gamma)$ ерөнхий томьёонд үндэслэгдсэн болно. Эмт бодисын жишиг итгэлцүүрийг тооцохын тулд эхлээд тухайн эмт бодисын амт, чадал, эрдмийг холбогдох ном эх сурвалжаас тодруулсан. Тухайн амтны чадал ба эрдмийн хувь хэмжээг тодорхойлоод гэм тус бүрд харгалзахыг хооронд нь нэмсэн. Эндээс гарсан тоог хий, шар, бадганы үндсэн бэлгэ чанарын хувь хэмжээнд хуваахад тухайн эмт бодисын жишиг итгэлцүүр дараах томьёогоор тооцов.

Эндээс $\Xi=f(\Gamma)$ ерөнхий томьёог задалж тооцоход:

$$\text{ЖИх}=\Xi12\text{х Г ЖИш}=\Xi13\text{х Г ЖИБ}=\Xi26\text{х Г}$$

ЖИ х.ш.б – хий, шар, бадган дарах жишиг итгэлцүүр

Ξ - эм;

Г - гэм (хий, шар, бадган)

Судалгааны хэрэглэгдэхүүнээр уламжлалт анагаах ухааны сурвалж зохиол Анагаах ухааны дөрвөн үндэс, Увдисын далай, Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул, Үзэгсдийн баясгалан, Маш гайхамшигт хуримын сан, Шүрэн таяг зэрэг сурвалж зохиолуудаас эх зохиол сурвалж судлалын арга, задлан шинжилж нэгтгэн дүгнэх арга, магадлан жагсаах аргазүйг ашиглан эмийн найрлагад орсон түүхий эд тус бүрийн амт, чадал, эрдмийг холбогдох эх сурвалжаас тодруулж өвчний заалтыг харьцуулав.

Эрхэм-8 эмийн түүхий эдүүдэд задлан шинжилгээ хийхдээ Cytoscape программ ашиглав. Cytoscape программ нь нээлттэй эх сурвалжийн дүрслэл, дүн шинжилгээ хийх, засварлахад чиглэсэн программ хангамж юм.

Үр дүн: Эрхэм-8 уламжлалт эм нь цул эрхтний халуун ялангуяа уушги, элэгний халуун, цус шар хямарсан халуун, хижгийн халуун зэрэг шинэ хуучирсан халуунд хэрэглэнэ. Эрхэм-8 уламжлалт эмийн найрлага дахь эмт бодисуудын жишиг итгэлцүүрийг тооцож үзэхэд гүргэм амтлаг, гашуун амттай, хүнд, сэрүүн, мохдог чадлаараа шар, хийг дарах эрдэмтэй бөгөөд хийг дарах ЖИ=0.83, шарыг дарах ЖИ=0.92 байж, элэгний халууныг арилгах, өвдөлт зогсоох, хавдар хариулах чадалтай дүйцэж байна. Жуган амтлаг амттай, тослог, сэрүүн, мохдог чадлаараа шар, хийг, гиван гашуун, амтлаг амттай, хүнд, сэрүүн, мохдог чадлаараа шар, хийг, башга гашуун амттай, мохдог, хөнгөн чадлаараа шар, бадганыг дарах эрдэмтэй бөгөөд шарыг дарах ЖИ=0.76 ба халууныг арилгах, хатгалгыг дарах, хорыг тайлах чадалтай байна. Дэгд гашуун амттай, сэрүүн, ширүүн чадлаараа шар, бадганыг, цагаан зандан эхүүн амттай, сэрүүн, мохдог, хөнгөн чадлаараа шар, бадганыг, цагаан бонаа гашуун амттай, сэрүүн, хөнгөн чадлаараа шар, бадганыг, хонлэн эхүүн амттай, сэрүүн, хөнгөн, ширүүн чадлаараа шар, бадган махбодыг тус тус дарж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Эрхэм-8 эмийн жишиг итгэлшүүрийг тооцсон үр дүн

Хийг дарах		Шарыг дарах		Бадганыг дарах			
Хүнд	Тослог	Сэрүүн	Мохдог	Хөнгөн	Шируун	Хурц	Халуун
3.75		1.87	2.62				
	1.5	1.87	2.62				
1.74		2.62	1.12				
			1.12	1.5			
		2.62			1.5		
		3.37	1.5	1.5			
		2.62		1.5			
		2.62		1.5	1.5		
6.99		26.57					

Эрхэм-8 уламжлалт эмийн найрлага дахь эмт бодисууд нь шарыг дарах сэрүүн чадалтай, халууныг арилгах үйлдэлтэй ба гурван гэмд харилцан адилгүй үйлчилж байгаа бөгөөд шарыг дарах жишиг итгэлшүүр 0.68 буюу шарын гэмийг илүү сайн дарж, дараа нь хийг дарах жишиг итгэлшүүр 0.58 ба бадганыг

дарах жишиг итгэлшүүр 0.16 байгаа нь бадганы гэмд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаагаас харахад цул эрхтний халуун ялангуяа уушги элэгний халуун, цус шар хямарсан халуун, хижгийн халуун зэрэг шинэ хуучирсан халуунд хэрэглэдэг байсантай тохирч байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Эрхэм-8 эмийн жишиг итгэлшүүр

Эмийн нэр	Хий дарах ЖИ	Шарыг дарах ЖИ	Бадган дарах ЖИ
Эрхэм-8	0.58	0.68	0.16

Эрхэм-8 эм нь сэрүүний эрхэм гиван, цагаан зандан, шимийн эрхэм жуган, гүргэм, тангийн эрхэм дэгд, башга, өвсний эрхэм хонлэн, цагаан бонаагаар голлосон 8 хөл эмт бодисыг хувь тэнцүүлэн талхдаж

найруулах бөгөөд цул савын халуун ялангуяа уушгины халуун, хижгийн халуун, шинэ, хуучин халуун бүхнийг хоцроолгүй арилгана гэж сурвалж зохиолуудад тэмдэглэн бичжээ (Хүснэгт 3).

Хүснэгт 3. Эрхэм-8 эмийн найрлага, тэдгээрийн чадлын талаар

УАУ-ны ном сурвалжид тэмдэглэсэн байдал^{2,3,16,17,22,23,24}

Эх сурвалж	Эмийн бүрэлдэхүүн	Чадал
Анагаах ухааны дөрвөн үндэс	Сэрүүн эмийн эрхэм болох гиван, цагаан зандан, шимийн эмийн эрхэм болох жуган, гүргэм, тан эмийн эрхэм болох дэгд, башга, өвсөн эмийн эрхэм болох хонлэн, цагаан бонаа хувь сацуу хийж, дөрвөн хувь цагаан чихэртэй найруулна.	Цул, савын халуун ялангуяа уушгины өвчин, элэгний цус шар, хямарсан халуун, хижгийн халуун зэрэг шинэ ба хуучирсан халууныг дарна. ⁴
Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул	Сэрүүний эрхэм гиван, цагаан зандан, шимийн эрхэм жуган, гүргэм, тангийн эрхэм дэгд, башга, өвсний эрхэм хонлэн, бонгарийг дөрвөн хувь цагаан чихрээр хөлөглөсөн Зову-8 эмийн үйлчлэл нь арвин боловч өөрийн ёсоор хувь сацуу найруулдаг.	Цул, сав, уушги, элэг, цус, шар, хямарсан ба хижгийн шинэ хуучин халууныг магад хоцролгүй дарах болно. ⁵
Маш гайхамшигт хуримын сан	Жуган, гүргэм, дигда, башга, бор үндэс арвайлаг үндэс, гиван, цагаан зандан зэргийг хувь тэгш найруулна.	Шинэ хуучин халууны үлдвэр урхагийг хоцролгүй дарна. Үүний дээр габүрыг нэмж хүчтэй халуунд хэрэглэнэ.
Шүрэн таяг	Жуган, гүргэм, башга, дэгд, зандангар, гиван, хонлэн, бонгар хөхийг хувь адил найруулна.	Нян халуун, муу дэлгэрснийг дарахын дээд нэг тунг өгснөөр чадна.
Мэйрэний Занги Коосикэн “Бүхнээ Туслах Элдэв Эмийн Найрлага”	Эрхэм наймуул (Зову-8) гиван 3 пүн, цагаан зандан 1 цэн, жуган 1 цэн, гүргэм 1 цэн, дэгд 3 цэн, башга 3 цэн, хонлэн 1 цэн, бонгар 1 цэн.	Хижиг, томуу ба цул, сав, элэгний шунасан цус, шарын хамаг үгдэрсэн хижиг, халуун хэтрээд утгаа алдсанд шилгавар хачирлаж өгвөөс сайн.

Эрхэм-8 эмийн бүрэлдэхүүнд жуган, гүргэм, башга, дэгд, цагаан зандан, гиван, бүтэн навчит хонлэн, бонааг хувь тэнцүү 1 граммаар найруулах бөгөөд уг эм нь чадлаар найрагдсан бор шаргал өнгөтэй


талх эм болно. Голдуу цул эрхтний халуун ялангуяа уушгины халуун, нянг нядлах, өвдөлт намдаах, халуун бууруулах, ханиалга намдаах зэрэг халуун өвчин бүхэнд хэрэглэнэ (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Эрхэм-8 эмийн бүрэлдэхүүн, үйлдэл^{4,5,9,12,27,30,58}

Монгол нэр	ШУ-ны нэршил	Хэмжээ /гр/	Амт чанар, эрдэм	Чадал
Гүргэм	<i>Carthamus tinctorius</i> L.	0.125	Өчүүхэн гашуун амттай, сэрүүн чанартай, хүнд мохдог зөөлөн эелдэг батлаг эрдэмтэй.	Цусны халууныг арилгах, судлын сүвийг боох, сарын тэмдгийг тэгшитгэх, элэгний халууныг арилгах, тамирыг сайжруулах, өвдөхийг зогсоох, хавдрыг хариулах
Гиван	<i>Bos taurus domesticus</i> Gmelin	0.125	Гашуун амтлаг амттай, сэрүүн чанартай, мохдог зөөлөн эелдэг хүнд чанартай.	Халууныг арилгах, хорыг тайлах, тайтгаруулах
Шороон жуган	<i>Schizostachoum chinense</i> RendleAit.	0.125	Өчүүхэн амтлаг амттай, сэрүүн чанартай.	Халууныг намдааж ханиалгахыг зогсоох, шарх анагаах, уушгины халуун бүхнийг арилган, шархны халууныг таслах.
Улаан башига	<i>Odontitis rubra</i> Baung.Opiz	0.125	Гашуун амттай сэрүүн, мохдог, хөнгөн, хөлбөрөнгүй чанартай	Цусны халууныг арилгах, хатгалгааг дарах, хижгийг эдгээх, өвчин намдаах, ханиахыг зогсоох, зүрхний үйл ажиллагааг дэмжих, элэгний халууныг дарах
Цагаан зандан	<i>Santalum album</i> L.	0.125	Эхүүн, гашуун амттай, хүйтэн, хөнгөн, хуурай, мохоо, зөөлөн чанартай	Ханиад томуу хүрч халуурах, уушги цээжээр хатгуулж, их халуурах, хямарсан халууныг арилгах, өвдөлт намдаах, шимжүүлэх, зүрхний халуун өвчин бүхэнд сайн
Хэвтээ дэгд	<i>Gentiana decumbens</i> L.	0.125	Эхүүн, гашуун амттай, хүйтэн, зөөлөн, эелдэг эрдэмтэй.	Ходоодны архаг үрэвсэл, цэсний хүүдийн үрэвсэл, мэдрэлийн ядаргаа, халуун бууруулах, ханиалга намдаах
Бүтэн навчит хонгөн	<i>Lagotis integrifolia</i> Schischk	0.125	Амтлаг, гашуун, эхүүн амттай, сэрүүн, ширүүн эрдэмтэй	Хорыг тайлах, цусны өвчнийг анагаах, хямарсан халуун, умайн халуун, цулын халууныг арилгах, цус шар дэлгэрсэн халуун өвчнийг дарах, сахуу, боом, богино хатгалгыг дарах
Бонаа	<i>Aconitum Kusnezoffii</i> Reichenb	0.125	Гашуун, бүлээн, тэгш	Нянг нядлах, халууныг арилгах, өвдөхийг зогсоох, шар ус хатаах

Эрхэм-8 эмийн 8 түүхий эдийн сүлжээний диаграммаас харвал эмийн зургаан амтаас гашуун, амтлаг, эхүүн амт, эмийн чанараас сэрүүн, мохдог, хуурай чанарын холбоос нь харьцангуй төвлөрч

байна. Эмийн чадлаас халууныг арилгах, өвдөлт намдаах, ханиалгахыг зогсоох зэрэг чадлын холбоосны харьцангуй төвлөрсөн үр дүнг зураг 1-д үзүүлэв.



Зураг 1. Эрхэм-8 эмийн найрлагад ордог түүхий эдүүдийн харилцан үйлчлэл

Хэлцэмж: Уламжлалт анагаах ухааны халуун өвчнийг өрнийн анагаах ухааны үрээсэл, халууралтын процесстой дүйцүүлэн үзэх боломжтой хэмээн адилтган үзсэн бөгөөд Эрхэм-8 уламжлалт эмийг уушгины халуун өвчин, хижгийн халуунд хэрэглэхийг заасан байдаг тул бид уламжлалт ном зохиолуудад бичиж тэмдэглэсэн уушгины халуун өвчний шинж тэмдгийг гэмийн бэлгэ чанараар нь ялган задалж, эмийн мөн чанартай нь уялдуулан шинжлэхэд $JHI=0.68$ буюу шарыг дарах үйлдэлтэй гэсэн нь эмийн заалттай тохирч байна.⁴ Эндээс харахад Эрхэм-8 эм нь амт, чадлаар найрагдсан эм байна.

“Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолын “Увдисын үндэс”-ийн 16 дугаар бүлэгт дэлгэрсэн халуун өвчнийг 7 зүйлээр үзүүлж, уушгинд халуун дэлгэрвэл амьсгал нь охордох, цээжний ар өврөөр хатгуулах, толгой эргэх, амьсгал цухалдах, хоолой сөөх, уушги зүрх нь дэлсэх, шөнө хэвтэхэд олон ханиалгах, нүүр ам нь сэлхрэх бөгөөд анагаахдаа Гавар-7 ба Эрхэм-8 дээр гаврыг нэмж өгнө гэж заасан бол “Маш гайхамшигт хуримын сан”-д 44 бүлэгт дэлгэрсэн халууны тухай өгүүлсэн ба уушгинд дэлгэрэхэд амьсгал охордож, шөнө уушгиар олонтоо хатгуулна. Засахдаа Зову-8 өгнө гэж заажээ. Мөн хямарсан халууны үед цул, савын гэмтсэн халуун нь өөр өөрийн дээр өвдөж хатгуулах ба зову-8 өгнө гэж сурвалж зохиолуудад тэмдэглэн бичсэн байна.^{2,16}

Эрхэм-8 эм нь сэрүүний эрхэм гиван, цагаан

зандан, шимийн эрхэм жуган, гүргэм, тангийн эрхэм дэгд, башга, өвсний эрхэм хонлэн, бонгарыг дөрвөн хувь цагаан чихрээр хөлөглөн хувь сацуу найруулах ба цайвар бор шаргал өнгөтэй, гашуун амттай, сэрүүн чанартай, халууныг арилгах чадалтай, ялангуяа цул эрхтний халуун буюу уушги, элэгний халуун, цус, шар хямарсан халуун, хижгийн халуун зэрэг шинэ ба хүүчирсан халуунд хэрэглэнэ.³

Дүгнэлт:

1. Эрхэм-8 эмийн шарыг дарах чадал хамгийн их буюу 0.68, хийг дарах чадал 0.58, бадганыг дарах чадал 0.16 байна.
2. Эрхэм-8 эмийн найрлагад орж байгаа түүхий эдүүд ихэнх нь гашуун, амтлаг, эхүүн амттай, халууныг арилгах чадалтай, ялангуяа цул эрхтний халуун буюу уушги, элэгний халуун, цус, шар хямарсан халуун, хижгийн халууныг арилгах зэрэг үйлдэлтэй бөгөөд Эрхэм-8 эм нь амт, чадлаар найрагдсан эм байна.

Ном зүй:

1. Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний Төв. Эрүүл мэндийн үзүүлэлт. Улаанбаатар; 2023:113-117.
2. Хөрвүүлсэн Х.Тумбаа. Анагаах ухааны дөрвөн үндэс. УБ; 1990:206-331, 607.
3. Дармаааарамба Лувсанчойрог. Зарлигийн эрхэст харанхуйг арилгагч зул. Шингийн гол аймгийн Монгол эмнэлгийн судлах газар. Өвөрмөцлөх ардын хэвлэлийн хороо; 1988:232-234.

4. Төмөрбаатар Н. Монгол анагаах ухааны халуун өвчин. *Улаанбаатар*; 1998:15.
5. Сээсрэгдорж С, Чимэдрагчаа Ч, Хишигжаргал С ба бусад. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увидаас. *Улаанбаатар хот*; 2005:127-130.
6. Лигаа У, Даваасүрэн Б, Нинжиг Н. Монгол орны эмийн ургамлыг өрнө, дорны анагаах ухаанд хэрэглэхгүй. *УБ*; 2006:343.
7. Лувсанчүлтэм. Эм таних ухаан. *Үндэстний хэвлэх хороо*; 1998:435.
8. Болдсайхан Б. Монгол орны эмийн ургамлын нэвтэрхий толь. *УБ*; 2004:112.
9. Олдох С, Цэрэнцоо Б, Батхуяг П. Монгол эмийн судлал. *Улаанбаатар*; 2009:169.
10. Ганбаяр Я. Монгол эмийн жорын гарын авлага. *Улаанбаатар*; 2001:243.
11. Сүрэнжав Ц. Монгол анагаах ухааны эм найрлагын судлал. *Хөх хот. ӨМАХХороо*; 1986:149.
12. Жамбал. Увидасын далай. *Модон бар судар*:383.
13. Чимэдрагчаа Ч, Дагвацэрэн Б, Хишигжаргал Л, Оюун З, Ариунаа З, Ууганбаяр Б, Наранцэцэг Г, Саранчимэг Б, Мөнхзүл Г. Уламжлалт эмт бодис, жорын хяналтын лавламж **3** дахь хэвлэл. *Улаанбаатар*; 2015:33, 249.
14. Хүрэлчулуун Б, Батчимэг Ө. Монгол эмэнд хэрэглэдэг гадаад ургамлын түүхий эд. *Улаанбаатар*; 2004:29,37,65.
15. Шүрэн таяг. Армийн хэвлэх үйлдвэр. *Улаанбаатар*; 1991.
16. Чойжамц. *Маш гайхамшигт хуримын сан. Армийн хэвлэх үйлдвэр. Улаанбаатар*; 1991:55-58, 129.
17. Лигаа У. Монголын уламжлалт эмнэлэгт эмийн ургамлыг хэрэглэх арга ба жор. *Тэргүүн боть. УБ*; 1996:408-410.
18. Ганбаяр Я. Монгол эмийн жорын хувилбар нэрийн түүвэр. *УБ*; 2010:116-174.
19. Монгол улсын стандарт. Уламжлалт талх эмийн ерөнхий стандарт. *MNS 5586-2006. Улаанбаатар. Үндэсний стандарт хэмжилзүйн газар*; 2006.
20. Монгол улсын үндэсний фармакопей. *Анхдугаар хэвлэл. УБ*; 2011:466-468.
21. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. *Анагаахын Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. УБ*; 2005.
22. Гоошиг майрны жор. Монгол анагаах ухааны эртний сонгодог зохиол цуврал бичиг. *Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо*; 1999:104.
23. Бэрх оньсны учир зангилааг тайлагч. Монгол анагаах ухааны эртний сонгодог зохиол цуврал бичиг: *Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо*; 1988:216-217.
24. IV дүрийн Миндол Номун хаан Жамбалчойжиданзанпэрэнлэй. Анагаах ухааны шастир бүгдийн шимийг нэгэн зүгт хураасан увидсын эрдэнэ гарахын орон хэмээх оршвой. *УБ хот. Очирпресс ХХК*; 2018:307-309.

Erkhem-8 traditional medicine effects on wind, bile, and phlegm reference coefficient and research on medicinal sourcebooks

Uugantsetseg G¹, Dejidmaa B², Chimedragchaa Ch², Amarzaya D², Erdenechimeg Ch², Alimaa T³

¹Department of public and traditional medicine of Darkhan-Uul Medical School, MNUMS

²Institute of Traditional Medical Technology

³International School of Mongolian Medicine, MNUMS

E-mail: uugantsetseg@mnms.edu.mn, Tel: +976-99398593

Background: Erkhem-8 medicine is a composed *Crocus Sativus* L, *Lagotis integrifolia*, *Gentiana barbata* froel etc, used for the treatment of respiratory diseases, specially pneumonia and fever or hot disease in Mongolian Traditional Medicine.

Aim: The effects of Erkhem-8 medicine to determine the some sourcebook study results.

Materials and Methods: An evaluation of its effects on wind, bile, and phlegm was conducted using Traditional Mongolian Medicine methods (Dagvatseren B, 1996). In order to clarify the structure and composition of Erkhem-8 traditional medicines, and the treatment of lung fever from traditional medical sources. Text and source-study and comparison method were used in the study.

Results: The study found that Erkhem-8 medicine demonstrated a varying capacity to suppress wind, bile, and phlegm, with bile suppression being the most significant at 0.68, followed by wind suppression at 0.58, and phlegm suppression at 0.16.

Erkhem-8 is composed of 8 ingredients, which are safflower *Carthamus tinctorius* L, gmeline *Bostaurus domesticus*, *Schizostachoum chinense* Rendle, wood *Santalum album* L, *Odontitis rubra* Baung.Opiz, flora *Gentiana decumbens* L, herba *Lagoti sintegrifolia* Schischk, flora *Aconitum Kusnezoffii* Reichenb. These herbs themselves have a variety of biological activities, including reduce heat, pain relief, anti-oxidant and anti-tumor, anti-inflammation activity.

Conclusions:

1. The study found that Erkhem-8 exhibited the highest suppression of bile (0.68), followed by wind (0.58), and phlegm (0.16), indicating its effectiveness in modulating these elements.
2. Most of the raw materials included in the composition of Erkhem-8 medicine have a bitter and sweet taste and have the ability to remove heat, especially heat of the solid organs, i.e. heat of the lungs, liver, blood, specially pneumonia and fever or hot disease in Traditional Mongolian Medicine.

Keywords: Erkhem-8 medicine, Lung hot diseases, Reference coefficient, Traditional medicine

